



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 11 дугаар сарын 22

Дугаар 5

Улаанбаатар хот

### V ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын өргөтгөсөн хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 08.00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 837 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ болон томуу, томуу төст өвчний нөхцөл байдал, эрүүл мэндийн салбарын бэлтгэл, бэлэн байдлын талаар

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун

3. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар

Эрчим хүчний сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн

4. Бусад



## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

### **Нэг. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболдод:**

- 1.1. Коронавируст халдвар /Ковид-19/ болон томуу, томуу төст өвчний тархалтаас хамаарч эмнэлгийн ачаалал нэмэгдэх эрсдэлийг бодитоор тооцоолж бэлтгэл, бэлэн байдлыг бүх шатанд хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- 1.2. Коронавируст халдварын /Ковид-19/ мутацилагдсан шинэ хувилбаруудын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэн даруй бүрдүүлэх;
- 1.3. Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчилж, эдгэрсэн иргэдэд сэргээн засах, тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

### **Хоёр. Аймаг, нийслэлийн Онцгой комисс, бүх шатны Засаг дарга нарт:**

- 2.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол, учруулах хохирлын тоо хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа тул болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаж, шаардлагатай нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлэх;
- 2.2. Хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хэмжээг бичигч багажийг худалдан авч хот, аймаг, сумын нутаг дэвсгэрт суурилуулах асуудлыг Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнтэй хамтран төлөвлөж, холбогдох зардлыг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гарган 2023 оны 2 дугаар улиралд багтааж шийдвэрлэх;
- 2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- 2.4. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т заасны дагуу тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулахаар тооцон орон нутгийн төсөвтөө тусган батлуулж, зарцуулах;
- 2.5. Төв, суурингаас алслагдсан нутагт өвөлжих иргэдэд төрийн болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг цаг алдалгүй, түргэн шуурхай хүргэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 2.6. Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, мэргэжлийн ангийн ажлын уялдаа холбоо, зохион байгуулалтыг сайжруулах, ус дулаан хангамж, холбоо, зарлан мэдээллийн найдвартай ажиллагааг тасралтгүй хангах, улсын болон орон нутгийн чанартай зам, даваанд үүрэг гүйцэтгэх зам арчлалт, аюулгүй байдал хариуцсан байгууллагуудын бэлэн байдлыг хангах ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- 2.7. Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд малчид иргэдийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх, орон нутгийн хэмжээнд цаг агаарын



болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллээр иргэдийг тогтмол хангах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллах;

**Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Бямбацогтод:**

3.1. Өвлийн их ачааллын горим ажиллагааны үед эрчим хүчний эх үүсвэрүүдэд 15-аас доошгүй хоногийн нүүрсний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай вагон тээврийн хангалтыг яаралтай нэмэгдүүлэх; /Нүүрсний тээвэрлэлт 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар “Багануур” ХК-д 40 вагон, “Шивээ Овоо” ХК-д 165 вагон, “Шарын гол” ХК-д 82 вагон тус тус төлөвлөгөөнөөс хоцрогдолтой байна/

**Дөрөв. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Ж.Ганбаатар:**

4.1. Эрчим хүчний үйлдвэр, компаниуд болон нүүрсний уурхайнуудад өвлийн их ачааллын үед шаардагдах дизель түлшний нийлүүлэлтийг тогтвортой хэмжээнд байлгах; дизель түлшний нөөцийг яаралтай бүрдүүлэхэд анхаарч ажиллах;

**Тав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой  
комиссын гишүүн Х.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга  
Д.Батчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

5.1. Бог малын мялзан өвчний хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаа Архангай, Булган, Дорноговь, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Төв аймагт хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, удирдлага, аргазүйгээр ханган тогтмол хяналт тавьж ажиллах;

5.2. Малчид, мал бүхий айл өрхүүд өвөлжөөндөө буусан, малын шилжилт хөдөлгөөн бүрэн зогссон 2023 оны 1-3 дугаар сард малын гоц халдварт өвчний тандалт, эмнэлзүйн үзлэг хийх ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул орон нутгийн түвшинд бэлтгэл ажлыг хангах, ажиллах хүний нөөц, санхүүжилтийг шийдвэрлэх;

5.3. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дахлаажуулалтын арга хэмжээг мэргэжлийн байгууллагаас товлосон хугацаанд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, дархлаажуулалтын ажлын үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.4. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 онд халдваргүйтгэлийн бэлдмэл, халдвар хамгааллын хувцасны нөөц орон нутгийн түвшинд бүрдүүлэх;

5.5. Мал эмнэлгийн арга хэмжээ хэрэгжүүлэх тов, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол давтамжтай хүргэх ажлыг хэрэгжүүлэх;

5.6. Малыг шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийн нэгдсэн судалгааг гаргаж (тухайн аймагт отроор ирсэн болон гадагш оторлож байгаа өрх, хүн, малын тоо), отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөний асуудлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, аргазүйгээр хангах;



**Зургаа. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн, Б.Жавхлан,  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун нарт:**

6.1. 2022-2023 оны өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэлтэй аймгуудад өвс, тэжээл нэмэлтээр худалдан авах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг Засгийн газрын нөөц сангаас олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

6.2. 2022-2023 оны өвөлжилт, хаваржилттай холбоотой асуудлаар /санхүүжилт, автомашин гэх мэт/ аймаг орон нутгуудаас ирсэн санал, хүсэлтийг нэгтгэн Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

**Долоо. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:**

7.1. Дизель түлшний нийлүүлэлт тасалдах эрсдэлд орсон “Багануур”, “Шивээ Овоо”, “Шарын гол” зэрэг нүүрсний уурхайд шаардлагатай түлшийг Улсын нөөцөөс холбогдох хууль, журмын дагуу олгож, нөхөн бүрдүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэх;

**Найм. Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,  
дэд хурандаа Т.Баярхүүд:**

8.1. Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, малын хорогдлоос урьдчилан сэргийлэх, экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар ахлуулсан ажлын хэсгийг Улсын онцгой комиссын даргын тушаалаар байгуулах;

8.2. Өвс, тэжээлийн хуримтлал, нөөц үүссэн аймаг, аж ахуйн нэгж байгууллагуудаас зудын эрсдэл өндөр гарсан аймаг, малчдад өвс, тэжээл хүргэх, шаардлагатай нөөц бүрдүүлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх, эрсдэлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсгийг Улсын онцгой комиссын даргын тушаалаар байгуулах;

8.3. Мах экспортод гаргадаг аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг нэг цэгээр хурдан шуурхай хүргэх, учирч буй хүндрэл бэрхшээлийг яаралтай шийдвэрлэх үүрэг бүхий Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар болон холбогдох бусад байгууллагын хамтарсан ажлын хэсгийг Улсын онцгой комиссын даргын тушаалаар байгуулах;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүүд даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ